

<p> ТӨГС ЭЗЭМШИХ С У Д А Р</p>
--

Матай 5:14–16

Та нарын гэрэл тийнхүү гэрэлтэг.

Агуулга

Уулан дээрх номлолдоо Есүс Христ Өөрийн шавь нарт сайн мэдээгээр амьдрах нь бусдад хэрхэн нөлөөлдөг талаар заадаг.

Сургаал эсвэл зарчим

Сайн мэдээгээр амьдардаг хүний үл-гэр жишээ нь бусдыг Бурханд ирэхийг урамшуулж чадна.

Биелүүлэлт

Хэзээ хэн нэгний үлгэр жишээ таныг сайн мэдээгээр амьдрахад тусалсан бэ? Ямар замаар та бусдад үлгэр жишээ болж чадах вэ?

<p> ТӨГС ЭЗЭМШИХ С У Д А Р</p>
--

Матай 11:28–30

Над уруу ир.

Агуулга

Зарим хүмүүс Есүсийг эсэргүүцэж байхад Тэрээр Түүнийг хүлээн авсан тэдэнд амлалтуудыг санал болгосон юм.

Сургаал эсвэл зарчим

Хэрэв бид Есүс Христэд ирэх аваас Тэр бидний ачааг хөнгөлнө.

Биелүүлэлт

Их Эээн хэзээ танд хүнд ачаагаа хөн-гөлөхөд тусалсан бэ? Та хэрхэн Түүнд илүү ойртох вэ?

Ачаа дарамтандаа гудайсан найз нөхөд, гэр бүлийнхэндээ урам дэм өгөхийн тулд та энэ шүлгийг хэрхэн ашиглаж болох вэ?

<p> ТӨГС ЭЗЭМШИХ С У Д А Р</p>
--

Лук 24:36–39

Амилсан бие мах болон ястай.

Агуулга

Дахин амилсан өдрөө Есүс Христ Ие-русалимд шавь нартаа үзэгдэж, тэдэнд Өөрийн амилсан биеийг харуулсан байдаг.

Сургаал эсвэл зарчим

Есүс Христ бол амилсан биет мөн. Амилсан бие мах болон ястай байдаг.

Биелүүлэлт

Есүс Христ үнэхээр амилсан гэдгийг мэдсэнээр таны гэрчлэл хэрхэн хүчир-хэгжсэн бэ?

<p> ТӨГС ЭЗЭМШИХ С У Д А Р</p>
--

Иохан 3:5

Ус болон Сүнснээс төрөх нь

Агуулга

Никодем хэмээх Фарисай хүн Есүс Христээс “дахин төрнө” гэж юу гэсэн утгатай болохыг асуудаг.

Сургаал эсвэл зарчим

Баптисм хүртэж, Ариун Сүнсийг хү-лээн авах нь сүнсээр төрж, селестиел хаант улсад ороход зайлшгүй шаард-лагатай ёслолууд юм.

Биелүүлэлт

Баптисм болон Ариун Сүнсний бэлэг нь таны амьдралд ямар өөрчлөлтүү-дийг авчирсан бэ? Баптисмын гэрээгээ сахиж, Ариун Сүнсний нөхөрлөлийг эрэлхийлэхийн тулд та юу хийж чадах вэ?

<p> ТӨГС ЭЗЭМШИХ С У Д А Р</p>
--

Матай 16: 5–19

Тэнгэрийн хаанчлалын түлхүүрүүд

Агуулга

Цезарь Филиппийн нутагт байхдаа Есүс Христ Өөрийн Төлөөлөгчдөд Сүмийг удирлахад юу чухал болох талаар зааварласан байдаг.

Сургаал эсвэл зарчим

Есүс Христийн Сүм Бурханаас ирэх илчлэлтүүд дээр баригддаг.

Санваарын түлхүүрүүдийг атгадаг тэдгээр хүмүүс дэлхий дээрх Бурханы хаант улсыг захирах эрх мэдэлтэй.

Биелүүлэлт

Ямар мөнхийн үнэнүүд танд илчлэгд-сэн бэ?

Санваарын түлхүүрүүдтэй Сүмийн удирдагчид таны амьдралыг ямар замаар адисалсан бэ? Санваарын түлхүүрүүдийг атгадаг Сүмийн удир-дагчдыг дэмждэг гэдгээ харуулахын тулд та юу хийх ёстой вэ?

<p> ТӨГС ЭЗЭМШИХ С У Д А Р</p>
--

Иохан 14:6

Зам, үнэн, амь.

Агуулга

Сүүлчийн зоогийн үеэр Есүс Христ Эцэгт хүрэх замыг шавь нар хэрхэн мэдэж болох талаар асуусан Томасын асуултанд хариулжээ.

Сургаал эсвэл зарчим

Мөнх амьдралыг хүлээн авч, Тэнгэр дэх Эцэгтэй хамт амьдрах цорын ганц зам бол Есүс Христ юм.

Биелүүлэлт

Та Эцэгт хүрэхээр тэмцэх зуураа Есүс Христэд итгэж, найдахын тулд юу хийж байна вэ?

<p> ТӨГС ЭЗЭМШИХ С У Д А Р</p>
--

Матай 22:36–39

Бурхан Эзэнээ хайрла; өөрийн хөршөө хайрла.

Агуулга

Есүс Христ хамгийн агуу тушаал нь юу болохыг асуусан Фарисайчуудад хариулжээ.

Сургаал эсвэл зарчим

Хамгийн агуу хоёр тушаал бол Бурха-наа хайрлах, хөршөө хайрлах юм.

Биелүүлэлт

Та хэрхэн зүрх, сэтгэл, оюун ухаанаа-раа Бурханыг хайрлах хайраа харуу-лах вэ? Та хэрхэн Түүний хүүхдүүдийг хайрлах вэ?

<p> ТӨГС ЭЗЭМШИХ С У Д А Р</p>
--

Матай 28:19–20

Бүх үндэстнүүдэд зааж, баптисм хүртээ.

Агуулга

Дахин амилсныхаа дараа Есүс Христ Өөрийн шавь нарт заавруудыг өгсөн байдаг.

Сургаал эсвэл зарчим

Есүс Христийн дагалдагчдын хувьд бид бүх үндэстнүүдэд зааж, баптисм хүртээх ёстой.

Биелүүлэлт

Та хэн нэгэнд сайн мэдээг суралцаж эсвэл баптисмын гэрээгээ сахихад нь хэрхэн туслах вэ?

Та номлолд үйлчлэхэд бэлтгэхийн тулд юу хийх вэ?

<p> ТӨГС ЭЗЭМШИХ С У Д А Р</p>
--

Үйлс 2:36–38

Наманчилж, баптисм хүртэж, Ариун Сүнсийг хүлээн ав.

Агуулга

Аврагчийг дахин амилснаас хойш тавин өдрийн дараа Төлөөлөгч Петр Иерусалимд цугласан олонд аврагда-хын тулд тэд юу хийх ёстойг заадаг.

Сургаал эсвэл зарчим

Наманчлал, гэм нүглүүдийн ангиж-ралын төлөөх баптисм нь биднийг Ариун Сүнсний бэлгийг хүлээн авахад бэлтгэдэг.

Биелүүлэлт

Нүглүүдээсээ уучлагдаж, Ариун Сүнсийг хүлээн авахын тулд юу хийх ёстойгоо мэдэхэд нь найздаа туслахын тулд та энэ судрыг хэрхэн ашиглах вэ?

<p> ТӨГС ЭЗЭМШИХ С У Д А Р</p>
--

Үйлс 3:19–21

Сэргээх цаг

Агуулга

Төлөөлөгч Петр Иерусалимд цугласан олонд хожмын өдрүүдийн талаар гэрчилжээ.

Сургаал эсвэл зарчим

Бүх цаг үеийн бошиглогчид хожмын үе дэх бүх зүйлийн сэргээлтийг урьд-чилан хэлжээ.

Биелүүлэлт

Их Эээн Хоёрдахь Ирэлтээсээ өмнө сайн мэдээг сэргээх ёстойг өөр ямар судрууд харуулж байна вэ?

<p> ТӨГС ЭЗЭМШИХ С У Д А Р</p>
--

1 Коринт 6:19–20

Таны бие бол ариун сүм.

Агуулга

Коринт дахь Сүмийн гишүүдэд бичсэн захидалдаа Төлөөлөгч Паул Гэгээнтнүүдэд хурыцлын нүгэл нь жигшүүртэй бөгөөд ноцтой болохыг заажээ.

Сургаал эсвэл зарчим

Бидний бие ариун сүмүүд шиг ариун нандин учраас цэвэр ариун байх ёстой.

Биелүүлэлт

Энэ судар даруу зохистой байдлын талаарх асуултуудад хариулахад хэрхэн туслах вэ? Ариун явдал? Шивээс болон биенийхээ аль нэг хэсгийг доолох? Мэргэн Ухааны үг?

<p> ТӨГС ЭЗЭМШИХ С У Д А Р</p>
--

1 Коринт 15:20–22

Христ дотор бүгд амилуулагдах болно.

Агуулга

Коринт дахь зарим Гэгээнтнүүд үхлийн дараа амилуулалт байхгүй гэж заадаг байсан учраас Төлөөлөгч Паул тэдний алдааг засахын тулд захидал бичжээ.

Сургаал эсвэл зарчим

Есүс Христ үхлийг ялж, амилсан уч-раас бүх хүн төрөлхтөн дахин амилах болно.

Биелүүлэлт

Есүс Христийн амилалтын талаарх гэрчлэлээ хэн нэгэнтэй хуваалц. Энэ сургаал хайртай нэгнээ алдсан хүмүү-сийг хэрхэн тайтгаруулах вэ?

<p> ТӨГС ЭЗЭМШИХ С У Д А Р</p>
--

1 Коринт 15:40–42

Алдар суугийн зэрэглэлүүд

Агуулга

Коринт дахь Сүмийн гишүүдэд бичсэн захидалдаа Төлөөлөгч Паул үхэгсэд хэрхэн босч, тэд ямар бие махбодоор амилуулагдах талаарх асуултуудад хариулжээ.

Сургаал эсвэл зарчим

Дахин амилсан биеүүд нар, сар, од гэрлээрээ ялгардаг шиг алдар суугаа-раа ялгардаг.

Биелүүлэлт

Сургаал ба Гэрээ 20:50–70-г унш. Та селестиел алдар суугийн амилсан биенийг хүлээн авахын тулд юу хийх ёстой вэ?

<p> ТӨГС ЭЗЭМШИХ С У Д А Р</p>
--

Галат 5:22–23

Сүнсний үр жимс

Агуулга

Галат дахь Гэгээнтнүүдэд бичсэн за-хидалдаа Төлөөлөгч Паул “Сүнс дотор явахыг” эрэлхийлдэг хүмүүст Сүнсний өгдөг шинж чанаруудын талаар заасан байдаг.

Сургаал эсвэл зарчим

Ариун Сүнстэй хамт байх нь ихэвчлэн хайр, баяр баясгалан, амар тайван, тэв-чээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал, дөлгөөн зан, өөрийгөө захирах зэрэг мэдрэмжүүдийг авчирдаг.

Биелүүлэлт

Та Сүнсний үр жимсийг хэзээ амссан бэ? Та Ариун Сүнсний нөхөрлөлийг урьж, амьдралдаа тэдгээр Сүнсний үр жимсүүдээс баяр баясгаланг олохын тулд юу хийх ёстой вэ?

<p> ТӨГС ЭЗЭМШИХ С У Д А Р</p>
--

Ефес 4:11–14

Төлөөлөгчид болон бошиглогчид Гэгээнтнүүдийг төгөлдөржихөд тусалдаг.

Агуулга

Ефест байгаа Гэгээнтнүүдэд бичсэн захидалдаа Төлөөлөгч Паул Сүмийн зохион байгуулалт хийгээд зорилгын талаар заасан байдаг.

Сургаал эсвэл зарчим

Сүм нь Гэгээнтнүүдийг төгөлдөр-жүүлж, сургамжилж, тохинуульын ажлыг гүйцэлдүүлэхийн тулд Бурханы өгсөн байгууллага юм.

Биелүүлэлт

Ямар замаар Сүмийн удирдагчид биднийг “аливаа номлолын салхинд туугдахаас” хамгаалдаг вэ?

Та хэрхэн хамгийн сайнаараа орон нутгийнхаа Сүмийн удирдагчид талархлаа илэрхийлэх вэ?

<p> ТӨГС ЭЗЭМШИХ С У Д А Р</p>
--

Филиппой 4:13

Би Христээр дамжуулан бүгдийг хийж чадна.

Агуулга

Шоронд хоригдож байх зуураа Төлөө-лөгч Паул Филиппой дахь Гэгээнт-нүүдийг урамшуулахын тулд захидал бичсэн байдаг.

Сургаал эсвэл зарчим

Есүс Христ Бурханы биднээс шаард-сан юуг боловч хийх хүчийг бидэнд өгөх болно.

Биелүүлэлт

Их Эээн танд сорилттой нүүр тулга-рах хүч чадлыг өгсөн цаг үеийнхээ тухай тэмдэглэлийн дэвтрэртэ бич.

<p> ТӨГС ЭЗЭМШИХ С У Д А Р</p>
--

2 Тесалоник 2:1–3

Урьдчилан зөгнөгдсөн урвалт

Агуулга

Тесалоник дахь зарим Гэгээнтнүүд Есүс Христийн Хоёрдахь Ирэлт тун удахгүй ирнэ хэмээн итгэж байлаа. Тэдэнд хандан бичсэн захидалдаа Тө-лөөлөгч Паул энэхүү буруу ойлголтыг засаж залруулжээ.

Сургаал эсвэл зарчим

Есүс Христийн Хоёрдахь Ирэлтээс өмнө урвалтын цаг үе байх ёстойг бошигложээ.

Биелүүлэлт

“Христ Өөрөө Сүмийг зохион байгуулсан цагаас хойш дэлхий дээр Христийн Сүм байсаар байгаагүй гэж үү? Яагаад Сэргээлт байх шаардлага-тай байсан юм бэ?” гэж асуух найздаа та хэрхэн хариулах вэ?

<p> ТӨГС ЭЗЭМШИХ С У Д А Р</p>
--

2 Тимот 3:15–17

Сургаал, шүүмжлэл, засвар заавруудад зориулан өгөгдсөн судрууд

Агуулга

Төлөөлөгч Паул Тимотод захидал би-чиж, Сүмийн гишүүдийн лунд болж буй сорилтуудыг даван туулахад нь түүнийг дэмжжээ.

Сургаал эсвэл зарчим

Судрууд дахь урам өгсөн сургаал, шүүмжлэл, засвар зааврууд нь бид-нийг аврал руу хөтлөхөд туслах болно.

Биелүүлэлт

Судруудыг судлах нь танд сургаалыг ойлгож, шүүмжлэлийг мэдэрч, засвар заавруудыг хүлээн авахад хэрхэн тусалсан бэ?

¹⁹Иймээс явж, бүх үндэстнийг дагалдагч болгогтун. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээж, ²⁰Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно гэж айддав.

—³⁶Багш аа, Хууль дахь агуу тушаал нь аль вэ? гэж асуув. ³⁷Тэр түүнд
—“Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла”. ³⁸Энэ бол агуу нь бөгөөд хамгийн чухал тушаал мөн. ³⁹Удаахи нь “Чи хөршөө өөрийн адил хайрла” гэсэнтэй адил юм.

¹⁵Тэр
—Харин та нар Намайг хэн гэж хэлэх вэ? гэсэнд, ¹⁶Симон Петр
—Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн гэв. ¹⁷Есүс түүнд хариуд нь
—Барiona Симон оо, чи ерөөлтэй еэ! Учир нь үүнийг чамд мах цус нь биш, харин тэнгэр дэх Миний Эцэг илчилсэн юм. ¹⁸Би мөн чамд хэлье. Чи бол Петр. Энэ хадан дээр Би Өөрийн чуулганыг босгох бөгөөд түүнийг Үхэгсдийн орны хаалга дийлэхгүй. ¹⁹Би чамд тэнгэрийн хаанчлалын түлхүүрийг өгнө. Чи газар дээр юуг холбоно, тэр нь тэнгэрт холбогдоно. Газар дээр юуг тайлна, тэр нь тэнгэрт тайлагдах болно гэлээ.

²⁸Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарт амралтыг өгье. ²⁹Буулгыг минь өөр дээрээ авч, Надаас суралц. Учир нь Би зүрх сэтгэлдээ дөлгөөн, даруу билээ. Тэгээд Та нар сэтгэлдээ амралтыг олох болно. ³⁰Миний буулга амархан, Миний ачаа хөнгөн гэв.

¹⁴Та нар бол дэлхийн гэрэл мөн. Уулан дээрх хот нуугдаж үл чадна. ¹⁵Хүмүүс дэнлүү асаагаад савны доор тавьдаггүй, харин дэнлүүний суурин дээр тавьдаг. Тэр нь гэрт байгаа бүгдэд гэрлээ тусгадаг билээ. ¹⁶Хүмүүс та нарын сайн үйлсийг хараад, тэнгэр дэх Эцэгийг тань алдаршуулахын тулд та нарын гэрэл тэдний өмнө тийнхүү гэрэлтэг.

³Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн.

¹⁵Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь.

⁶Есүс
—Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй.

⁵Есүс
—Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй.

³⁶Тэд ийнхүү ярьж байтал Тэр Өөрөө тэдний дунд зогсож байлаа. Тэр тэдэнд
—Амар амгалан нь та нарт байх болтугай гэв. ³⁷Гэвч тэд айн сандарч, сүнс үзэгдэв хэмээн боджээ. ³⁸Есүс тэдэнд
—Та нар юунд зовж, зүрхэнд чинь эргэлзээ төрнө вэ? ³⁹Миний гар, Миний хөлийг хараач. Энэ чинь Би Өөрөө байна. Надад гараа хүргээд үз. Учир нь сүнсэнд та нарын харж байгаа Над шиг яс, мах байдаггүй юм гэв.

⁴⁰Мөн тэнгэрлэг биес ба газрын биес гэж байдаг. Харин тэнгэрлэг биесийн алдар өөр, газрын биесийн алдар өөр юм. ⁴¹Нарны алдар өөр, сарны алдар өөр, одны алдар өөр байдаг. Од одноосоо алдраараа ялгардаг. ⁴²Үхэгсдийн амилалт нь тийм байна. Энэ нь муудах байдал дотор таригдаж, үл муудах байдал дотор амилуулагдана.

²⁰Харин чухамдаа Христ үхэгсдээс амилуулагдсан бөгөөд нойрсогсдоос анхны үр жимс мөн. ²¹Учир нь үхэл нь нэг хүнээр ирсэн тул үхэгсдийн амилалт нь мөн нэг хүнээр иржээ. ²²Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьдруулагдах болно.

¹⁹Та нарын бие бол Бурханы та нарт өгсөн, та нарын дотор байдаг Ариун Сүнсний сүм мөн гэдгийг та нар мэддэггүй юм уу? Та нар өөрсдийнх биш гэдгээ мэддэггүй юм уу? ²⁰Учир нь та нарыг үнээр худалдан авсан юм. Тиймээс биеэрээ Бурханыг алдаршуулагтун.

¹⁹Иймээс гэмшицгээ. Нүглүүдээсээ салахын тулд эргэцгээ. Тэгвэл сэргээх цаг Эзэний оршихуйгаас ирэх бөгөөд ²⁰та нарын төлөө томилогдсон Христ болох Есүсийг Тэр илгээх болно. ²¹Бурхан Өөрийнхөө ариун эш үзүүлэгчдийн амаар эрт цагаас айдсанчлан бүхнийг сэргээх үе хүртэл Түүнийг тэнгэр хүлээн авах ёстой юм.

³⁶Тиймээс Бурхан та нарын цовдолсон тэр Есүсийг Эзэн, бас Христ болгосныг Израилийн айл бүхэн баттай мэдэгтүн гэв.
³⁷Сонссон зүйл нь тэдний зүрхийг хөндсөнд, Петр болон бусад элч нараас
—Ах дүү нар аа, бид одоо яах вэ? гэж асууцгаав. ³⁸Петр тэдэнд
—Гэмшигтүн, хүн бүр өөрсдийн нүглийн уучлалын төлөө Есүс Христийн нэрээр баптисм хүртэцгээ. Та нар ч Ариун Сүнсний бэлгийг авах болно.

¹⁵Христ Есүст итгэх итгэлээр дамжуулан авралд хүргэх мэргэн ухааныг чамд өгөх чадалтай Ариун Бичээсүүдийг чи бага наснаасаа мэдэх болсон. ¹⁶Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал дотор чиглүүлэхэд тустай. ¹⁷Энэ нь Бурханы хүн аливаа сайн үйлд бүрэн бэлтгэгдсэн байхын тулд юм.

²Ах дүү нар аа, бидний Эзэн Есүс Христийн ирэх хийгээд бидний Түүн уруу цуглах тухайд эдүгээ бид та нараас гуйж байна. ²Эзэний өдөр ирчихлээ хэмээн та нар ухаан бодлоороо тэр даруй ганхаж дайвалгүй, эсвэл сүнсээр ч юм уу, эсвэл үг яриагаар ч юм уу, эсвэл биднээс ирсэн мэт захидлаар ч үймүүлэгдэхгүй байгтун. ³Хэн ч та нарыг ямар ч аргаар бүү мэхлэг. Учир нь эхлээд итгэлээс салах явдал гарч, сүйрлийн хөвгүүн болох ёс бусын хүн илчлэгдэхээс нааш тэр өдөр ирэхгүй.

¹³Надад хүч өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна.

¹¹Тэр заримыг нь элч, заримыг нь эш үзүүлэгч, заримыг нь сайн мэдээг тунхаглагч, заримыг нь хоньчин ба багш болгожээ. ¹²Эдгээр нь ариун хүмүүсийг үйлчлэлийн ажилд бэлтгэж, Христийн биеийг байгуулахын тулд юм. ¹³Бид бүгд итгэл хийгээд Бурханы Хүүг мэдэх мэдлэгийн нэгдэл хүртэл, төлөвшсөн хүн болтол, Христийн дүүрэн байдлын чанарын хэмжээнд хүртэл ингэх ажээ. ¹⁴Үүний үр дүнд бид цаашид хүүхэд байхаа больж, давалгаанд энд тэнд шидэгдэн, аливаа номлолын салхи, хүмүүсийн ов мэх болон зальхай хуйвалдааны башир арганд туутдалгүй,

²²Харин Сүнсний үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал, ²³дөлгөөн зан, өөрийгөө захирах байдал нь юм. Эдгээрийн эсрэг хууль гэж байдаггүй юм.

¹² Үхсэн их бага хүмүүс сэнтийний өмнө зогсож байхыг би харлаа. Номууд дэлгээстэй байв. Өөр нэгэн ном дэлгээстэй байсан бөгөөд тэр нь амийн ном юм. Үхэгсэд нь өөрсдийн үйлсийн дагуу энэхүү номд бичигдсэн зүйлсээр шүүгдэв.

⁶ Учир нь энэ зорилгын үүднээс сайн мэдээ үхэгсэдэд ч хүртэл тунхаглагдсан. Ингэснээр тэд махан биеэрээ хүмүүсийн адил шүүгдсэн боловч, Бурханы хүслийн дагуу сүнс дотор амьд байх юм.

¹⁷ Иймээс ч итгэл нь хэрэв үйлсгүй бол өөрөө үхмэл юм.
¹⁸ Гэвч хэн нэг чинь "Чамд итгэл байна. Харин надад үйлс байна. Чи надад итгэлээ үйлсгүйгээр харуул. Би чамд өөрийн итгэлийг үйлсээрээ харуулья" гэж хэлж болох юм.

⁵ Харин та нарын хэн нэгэн нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно. ⁶ Харин тэр ямар ч эргэлзээгүйгээр итгэлээрээ гуйг. Учир нь эргэлзэгч нэгэн нь салхиар туугдан давалгаалах тэнгисийн долгио мэт ажээ.

⁹ Биднийг сахилгажуулдаг махан биеийн эцгүүд бидэнд байсан. Бид тэднийг хүндэлдэг байсан бол тэгэх тусмаа бид сүнснүүдийн Эцэгт захирагдан амьдрах нь үлэмж дээр бус уу?

Өдөр бүрийн судрын уншлагын хүснэгт

1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
3	3	3	3	3	3	3	3	3	3	3	3
4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4
5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5
6	6	6	6	6	6	6	6	6	6	6	6
7	7	7	7	7	7	7	7	7	7	7	7
8	8	8	8	8	8	8	8	8	8	8	8
9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9
10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10
11	11	11	11	11	11	11	11	11	11	11	11
12	12	12	12	12	12	12	12	12	12	12	12
13	13	13	13	13	13	13	13	13	13	13	13
14	14	14	14	14	14	14	14	14	14	14	14
15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15
16	16	16	16	16	16	16	16	16	16	16	16
17	17	17	17	17	17	17	17	17	17	17	17
18	18	18	18	18	18	18	18	18	18	18	18
19	19	19	19	19	19	19	19	19	19	19	19
20	20	20	20	20	20	20	20	20	20	20	20
21	21	21	21	21	21	21	21	21	21	21	21
22	22	22	22	22	22	22	22	22	22	22	22
23	23	23	23	23	23	23	23	23	23	23	23
24	24	24	24	24	24	24	24	24	24	24	24
25	25	25	25	25	25	25	25	25	25	25	25
26	26	26	26	26	26	26	26	26	26	26	26
27	27	27	27	27	27	27	27	27	27	27	27
28	28	28	28	28	28	28	28	28	28	28	28
29	(29)	29	29	29	29	29	29	29	29	29	29
30		30	30	30	30	30	30	30	30	30	30
31		31		31		31	31		31		31

Өдөр бүрийн судрын уншлагын хүснэгт

1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
3	3	3	3	3	3	3	3	3	3	3	3
4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4
5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5
6	6	6	6	6	6	6	6	6	6	6	6
7	7	7	7	7	7	7	7	7	7	7	7
8	8	8	8	8	8	8	8	8	8	8	8
9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9
10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10
11	11	11	11	11	11	11	11	11	11	11	11
12	12	12	12	12	12	12	12	12	12	12	12
13	13	13	13	13	13	13	13	13	13	13	13
14	14	14	14	14	14	14	14	14	14	14	14
15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15
16	16	16	16	16	16	16	16	16	16	16	16
17	17	17	17	17	17	17	17	17	17	17	17
18	18	18	18	18	18	18	18	18	18	18	18
19	19	19	19	19	19	19	19	19	19	19	19
20	20	20	20	20	20	20	20	20	20	20	20
21	21	21	21	21	21	21	21	21	21	21	21
22	22	22	22	22	22	22	22	22	22	22	22
23	23	23	23	23	23	23	23	23	23	23	23
24	24	24	24	24	24	24	24	24	24	24	24
25	25	25	25	25	25	25	25	25	25	25	25
26	26	26	26	26	26	26	26	26	26	26	26
27	27	27	27	27	27	27	27	27	27	27	27
28	28	28	28	28	28	28	28	28	28	28	28
29	(29)	29	29	29	29	29	29	29	29	29	29
30		30	30	30	30	30	30	30	30	30	30
31		31		31		31	31		31		31

